



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2005 оны 10 сарын 20 өдөр


Дугаар 318

Гадаадад суралцуулах тухай

Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2005 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам" болон Хүнс, хөдөө аж ахуйн сайдын зөвлөлийн 2005 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 6 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жамбал овогтой Төмөрхуягийг 2005-2006 оны хичээлийн жилээс Япон улсын Obihiro Их сургуулийн магистрантурт газар тариалангийн чиглэлээр Хүнс, хөдөө аж ахуйн яамны захиалгаар 2 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Боловсролын газрын Мэргэжлийн боловсролын хэлтэс /Д.Баяр/-т тус тус даалгасугай.



САЙД

П.ЦАГААН

99999999